

ШАШНЫ ТУХАЙ Л. ФЕЙЕРБАХЫН БАРИМТЛАЛ

Ж. Каламхас

Дархан-Уул аймгийн ТДС-ийн суурь боловсролын тэнхим

Түлхүүр үг: шашин, бурхан, айдас, мэдрэмж, хэрэгцээ, хүсэл

Эрт дээр үеэс эдүгээ хүртэл философид шашин, түүний үүслийн тухай ойлголт олон янзаар тайлбарласаар ирсэн билээ. Тухайлбал “Шашин бол алдагдсан сэтгэлийг өөрт нь байнга сануулж байдаг гүн хүндэтгэлийн хүч, эрхэм нандин зүйл”, “Шашин бол хуурмаг зүйл”, “Шашин” бол итгэл, бишрэл, шүтлэг гэх мэт.

Л.Фейербах /1804-1872/ нь 1841 онд хэвлүүлсэн “Христос шашны мөн чанар”, 1845 онд бичсэн “Шашин мөн чанар” зэрэг бүтээлдээ шашны үүсэл, мөн чанарын талаар өгүүлжээ.

Тэрээр шинжлэх ухаан байгаа газарт шашны хэрэг байдаггүй гэж үзжээ. Хүмүүсийг сүсэгтэн бус, боловсролтой болгох нь чухал. Боловсрол нь хүмүүсийг шашны мухар сүсгээс чөлөөлнө хэмээн шашныг үгүйсгэн шүүмжилж байжээ.

Шашин нь сэтгэхүйн үйл ажиллагаа, ерөнхий үзэл санаа, ойлголтыг бие даасан чанартай хэмээн мэдрэхүйн тодорхой ахуйгаас салгасны үр дүнд үүссэн. Шашин үүсэн шалтгааныг Л.Фейербах хүний хийсвэр хүсэл тэмүүлэл, сэтгэл зүйн төлөв байдалтай холбон авч үзсэн буй.

Л.Фейербахын шашны тухай баримтлал нь үүссэн цагаасаа эхлэн эдүгээ хүртэл судлаачдын анхаарлыг татсаар байгаа юм. Учир нь Л.Фейербах шашны мөн чанарыг нэлээд гүнзгий судалдсан хүн юм. Тэрээр шашин хүний өөрийн хэрэгцээнээс үүссэн болохыг үзжээ.

Л.Фейербахын баримтлалын нэг онцлог нь түүний “үндэс”, “язгуур”, “эх булаг”, “дэвсгэрийн” тухай үзэл юм.

Түүний үзлээр, Шашин нь байгалийн үл мэдэгдэх хүчнээс айж эмээснээс үүсдэг. “Шашны үндэс нь хүний бие даасан мэдрэмжийг бүрдүүлдэг бөгөөд энэ мэдрэмжийн хамгийн гол илэрхийлэл нь айдас юм”. Энэ мэдрэмж бүрэлдэх болсон анхны шалтгаан нь байгалийн үзэгдлийг хувирамтгай тогтворгүй байдал, гэнэтийн үзэгдлүүдийн цогцтой холбоотой. Цаашилбал “айдас нь шашны үүсэл болсон эхний хийгээд анхны үндэс байсан юм” гэж Л.Фейербах үзжээ. Байгаль нь үргэлж хөдөлгөөн, хувиралд

оршдог учир энэ өөрчлөлтүүд хүний үүсэл зорилгод тааламжтай болон тааламжгүй, эерэг болон сөргөөр нөлөөлж, хүнд өөрийн эрхгүй бүрэн ухамсарлахгүйгээр байгалийн мөн чанарыг оюун санааны субъектив зүйл мэт хүлээн авдаг ажээ. Эрт үеийн хүмүүсийн хувьд байгалийн үзэгдэл хувирал нь шүтлэгийн мэдрэмж бий болгож, байгалийг шүтлэгийн зүйл мэт дүрслэл бий болгон түүнийгээ тахин шүтэх болжээ. Байгаль гэдэг ойлголтонд бурхан, хий хоосон зүйлсүүдийн аль нь ч хамаарахгүй юм. Бурханлиг буюу мөнхийн чанар гэдэг нь хүний сэтгэлийн мөн чанар мөн бөгөөд энэ нь хүнээс салангид биеэ даасан мөн чанар мэт оршдог. "Бурхан бол оюун санаа юм" гэжээ. Субъект нь ямар байна объект нь тийм байна, сэтгэхүй ямар байна танин мэдэхүйн объект тийм байна гэж Л.Фейербах үзэж байв.

Энэ талаар "Шашныг айх, баярлах гэсэн тодорхой мэдрэмжүүд дээр нь ерөнхийлөн тайлбарлаж болохгүй ч гэсэн эдгээр мэдрэмжүүд нь тодорхой нөхцөлд шашныг илэрхийлэх гол үндэс болж байдаг" гэж Л.Фейербах үзжээ.

Үхлээс айх эсвэл баяр баясгалан нь амьдралын мэдрэмж юм. Айх гэдэг нь ямар нэг зүйлээс хамааралтай Би нь юу ч биш, намайг тэр юм устгаж чадна гэсэн мэдрэмж юм. Баяр баясгалан, талархах мэдрэмж гэдэг нь ямар нэг юмнаас хамааралтай, түүний ачаар би амьдарч, оршин тогтнож байгаа гэсэн мэдрэмж юм. Айх мэдрэмжийн эх үүсвэр нь урьд хэлсэнчлэн байгалийн үзэгдлүүдээс хамааралтай гэдгийг нотлон Л.Фейербах дараах жишээг дурдсан байна. "Хэрвээ нар шингэлгүй тэнгэрт мөнх хадаатай байвал тэр нь хэзээ ч шүтлэгийн сэтгэгдэл төрүүлэхгүй гэж үзэж байжээ. Нар эргэж ирэн өглөөг гийгүүлэх үед хүмүүс түүний өмнө өвдөг сөхрөн толгой гудайлгаж баярлах сэтгэлд умбан байдаг бол нар нүднээс алга болох үед шөнийн харанхуй айдаст автдаг юм гэж Л.Фейербах өгүүлжээ.

Л.Фейербах эдгээр үзэгдлүүдийг философийн хэлнээ буулгахдаа, шашин шүтлэгийг тохиолдлын байдалтай холбож үзсэн. Тохиолдол бол шашин шүтлэгийн гол зүйл нь болдог бөгөөд тэр нь урьдчилан бодох бололцоогүй, өөрийн эрхгүй хүний мэдлэг болон хүсэл зоригоос үл хамааран тухайн үед хүний хувь заяа юунаас шалтгаалж байгаагаас болдог юм гэж тэрээр тайлбарласан буй.

Шашин шүтлэгийн өөр нэг гол үндэс нь хүний хэрэгцээ, хүсэл хувиа бодох бодолтой холбоотой гэж Л.Фейербах үзжээ. Хүн нь хувиа бодох

шаардлагагүй бол бие даасан мэдрэмж байхгүй. Хувь хүн эд зүйлс болон тодорхой нэг юманд сэтгэл ханахгүй байдаг. Тийм ч учраас бие даасан байдлаа байнга өгүүлж байдаг. Хэрэв эд зүйлс бусдын мэдлэг байдаг бол энэ нь засгийн зүйлс болон илэрхийлэгддэг. Хэрвээ хүссэн зүйлээ олж авч сэтгэл ханасан бол түүний захирах болон хувийн үзэл бодол илэрдэг байна. Энэ зөрчлийн мөн чанар нь өөртөө бие даасан мэдрэмжийг бий болгодог. Хэрэгцээ шаардсан хэн нэгэн хүн хайж явсан зүйлээ олж авч чадсан бол түүний хоёр тал болох тэр эд зүйлс захиран, эсвэл өөрөө эд зүйлсдээ захирагдах мэтчилэн шашны болон шашны бус зүйл болон хуваагддаг байна. Л. Фейербах хэрэгцээ хүсэл хоёр холбоотой гэж тэмдэглэжээ. Хүнд юу хүсэж байгаа болон юуг зайлуулах ёстойг мэдэх мэдлэг суулгах ёстой юм гэжээ. Өөрөөр хэлбэл, шашин гай гамшигаас чөлөөлөгдөх хүсэл төрүүлэх, эсвэл ямар нэг зүйлээс болгоомжилсон эсвэл сайн үйл бүтээхийг хүссэн бол аз жаргалтай байх хүсэл эрмэлзлэлийг илэрхийлж байгаа хэрэг мөн. Бурхан хүний дээд хүслэн бөгөөд түүнийг бодит байдлаар бодсон зөвхөн л бодол юм гэжээ. Бурхан гэдэг маань аз жаргал руу тэмүүлэх зөгнөлийн илэрхийлэх явдал юм гэжээ. Хэрэв хүн ямар ч хүсэл тэмүүлэлгүй, зөгнөх мэдрэмжгүй байсан бол ямар ч шашин бурхан байхгүй байсан.

Ийнхүү аз жаргал, хайр сэтгэлийн төлөөх хүсэл тэмүүлэл хүний хувийн үзэл гэж үзээд Л.Фейербах үүнийг шашны анхны үндэс гэж үзжээ.

Түүнчлэн шашин гэдэг нь ганцхан практик зорилго үндэслэлтэй гэж Л.Фейербах үзжээ. Шашин шүтлэгээс хүсэл тэмүүлэл төрдөг түүний эцсийн зорилго нь аз жаргал олох явдал. Хүн ямар байхыг хүснэ, түүгээрээ бурхныг дүрсэлдэг. Адгуус хүнтэй адил гадаад орчны нөлөөнд байх боловч оюун санааны амьдрал, сэтгэхүй, дүрслэхүй, төсөөлөл байхгүй учир тэдний хувьд бурхан байхгүй. Хүний хувьд сайн сайхан руу байнга тэмүүлж байдаг учраас бурхан хэмээх ойлголтыг бий болгосон. Бурхан бол хийсвэрлэл юм.

Хүн өөрийн үйлдэлгүй бол ямар ч захирах эрх мэдэл олж авч чадахгүй, хүсэл болон түүний биелэлт, зорилго ба түүний хэрэгжилтийн хооронд янз бүрийн бэрхшээл ба бололцооноос шалтгаалан өөрийнхөө зорилгыг хэрэгжүүлэх бололцоогүй болох тохиолдолд хүн өөрийн зөгнөлийн хоосон зайг зорилго ба биелэлт, хүсэл ба бодит байдал хоёрын хоорондын ан цавыг дүүргэхийн тулд бие даасан байдал ба шалтгааныг хүсэл зорилго болгон чин сэтгэлийн тэмүүлээ биелүүлж өгөөч гэж залбирал үйлддэг юм. "Шашны урьдчилсан нөхцөл нь хүсэл ба биелэл, мөрөөдөл ба чадвар,

төлөвлөлт ба биелэлт, төсөөлөл ба бодит байдал, оюун санаа ба ахуйн хоорондын харилцаанаас хамаарна” гэж Л.Фейербах үзэж байжээ.

Шашин нь хүний хүсэл, хүний хэрэгцээнээс үүсэж байгаагаараа онцлогтой бөгөөд хүн амьдралаас тэртээ тэргүй ханамж авч өөрөө өөрийгөө хангаж байдаг. Хүн үргэлж байгальтай харьцаж, тэр харьцаа нь хүнийг төрүүлж бий болгож бас үгүй ч болгож байдаг.

Тэрээр хэлэхдээ, шашин нь нийгмийн байдлаасаа шалтгаалаад янз бүрийн мөн чанар, агуулагтай болж хувирдаг хий хоосон зүйл бөгөөд хэрэв бидний үзэл бодолд улс төрийг шашин болгож хувиргасан тохиолдолд улс төрийг шашнаар сольж болно гэжээ. Байгалийн боол нар, саранд мөргөнө. Харин нийгмийн боол нь төр цаазын өмнө мөргөнө. Үнэндээ бурхан хүнийг бүтээгээгүй, хүн бурханыг бүтээсэн болно.

Эцсийн эцэст хүн өөрөө бурхан гэж шүтэгдэх тийм шашин л байх болно. Хүн хүндээ бурхан байх тийм шашин хамгийн зохистой хэмээн үзжээ. Хүн төрөлхтний практик хүсэл эрмэлзлэл улс төрийн хэрэгт идэвхийлэн оролцох нөхцөлд бүрэлддэг. Төрийн үйл хэрэгт нэгдэн нийлж, өөрийн шашныг эсэргүүцэж, төрийн субъектив тайлбар нь хүмүүсийн итгэл найдвартай суурилна гэдгийг мартаж болохгүй гэжээ. Төрийн үйл ажиллагаанд нэг нь нөгөөгөө орлож, нэг нь нөгөөгөө дүүргэж байдаг нь хязгааргүй үйл явц мөн бөгөөд хүмүүс төрд зүтгэж байгаа нь бурхангүй үзэл юм. Тэдний хувьд төр өөрөө бурхан болж байгаа юм. Улс төрийн цэнэг нь шашингүй үзэл болон хувирч тэдний хувьд улс төр нь шашныг оролдог.

Л.Фейербахын үзлээр, төр нь хүмүүсийн нэгдмэл цогц бөгөөд нийгмийн бүх хүмүүсийн зориг, хүслийг илэрхийлэгч олон талтай нэвтэрхий нэгэн хүн юм гэж үзжээ. Төрийн үүсэл нь хүмүүсийн шашин шүтлэгийн хэр хэмжээтэй холбоотой юм. Жинхэнэ утгаараа шашин нь төрийн үүсэлд саад болж байгаа бөгөөд ер нь бурхан шүтэх явдал бол төрд нэгдэхэд саад болж, төрийн хүч чадлыг сулруулагч юм гэж цохон тэмдэглэжээ. Жинхэнэ ёсондоо бурхан бишрэлээс татгалзаж, шашны эсрэг тэмцэх нь хүмүүс төрийг байгуулж түүнд нэгдэхэд хүргэдэг гэж тэрээр үзжээ.

Л.Фейербахын үзлээр, шашин бол байгалийн ба оюун санааны шашин гэж ялгарна. Байгалийн шашин бол байгалийг бурханчлан шүтдэг эртний шашин шүтлэг юм. Харин оюун санааны шашин бол хүний оюун ухааныг бурханчлах үзэл юм. Шашин үүсэхэд нөлөөлсөн нэг гол зүйл бол хүмүүсийн оюун ухааны хөгжил сул дорой байсан явдал хэмээн үзжээ.

Ном зүй

- Р. Дарьхүү, Д. Оюунгэрэл. **Философи** УБ, 2006
- Александров. Г. Ф. **История западно Европейской философии** М, 1946г
- **Великие философы /словарь справочник/** М, 1974г
- **Западная философия от истоков до наших дней. Том 4** М, 1986г
- **Историко – философские предпосылки религиоведения** М, 1980г
- **История философия** М, 1967г
- **Философия /учебник/** М, 1999г
- **Хрестоматия по истории философии от Лао Цзы-Фейербах** М, 1998г
- **Яблоков. И. Н. Религиоведение** М, 1998г